ВИДЕО ШТОРК · 2024 оны 1-р сарын 30

2023 ОНД ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ 28.8 ХУВИАР ӨССӨН БАЙНА



Гэмт хэргийн улмаас бусдад учирсан эд хөрөнгийн хохирол 2023 онд хоёр дахин өсөж, 14.8 их наяд төгрөгт хүрснээс 11.7 их наяд төгрөг буюу 79 хувь нь нөхөн төлөгдсөн байна.

Прокурор хохирлыг нөхөн төлүүлэх, хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор мөрдөн шалгах ажиллагааны явцад нийт 306.5 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслийн бүртгэл, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, 530.4 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх зөвшөөрөл олгож, хөрөнгө хамгаалах арга хэмжээ авсан бөгөөд хохирол нөхөн төлүүлэлт 2022 онтой харьцуулахад 28.8 хувиар өсжээ.

Видео: https://www.youtube.com/watch?v=jymGTEN9Vkk

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1432